

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/015/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын
Орлогч: Я.Самбууням
Утас:261945 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Ахлах аудитор:М.Пагамдулам
Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn
Аудитор: Б.Отгонцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСАУ	Бүгд Найрамдах Солонгос Ард улс
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ДАХШҮГ	Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газар
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УАУЭСК	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
ЦССҮТ	Цус сэлбэлт судлалын үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭСҮТ	Эмгэг судлалын үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭЭХХЗГ	Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

2025.04.25 № 1587
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 113,860.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн, улсын комисс хүлээж авсан 25,296.9 сая төгрөгийн барилга, 870.6 сая төгрөгийн их засвар, 2,533.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 2,532.5 сая төгрөгийн хөрөнгийг 22 эрүүл мэндийн байгууллага данс бүртгэлдээ тусгаагүй;
- Өмнөх онуудад хэрэгжиж дууссан 17 ажлын 129.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад баригдаж ашиглалтад орсон 28,574.2 сая төгрөгийн 22 барилга, 349.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй, давхар бүртгэсэн.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.6, 20 дугаар зүйлийн 20.2.6, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.5, 5.4.6, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн хүрээнд дүрс оношилгооны дүгнэлт, зураг харах боломжийг E-Mongolia системд нэвтрүүлэн 21 аймгийг дүрс архивлах төвлөрсөн PACS системд холбож, Улаанбаатар хотоос зайн оношилгооны үйлчилгээг орон нутагт үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, 2024 оны 1 дүгээр сарын 12-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганаар батлуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улс, Бүгд найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу "Эксим" банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлсэн 52,887.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Үндэсний оношилгоо эмчилгээний төв"-ийн барилгыг 2024 оны 3 дугаар сард бүрэн ашиглалтад оруулснаар олон улсын чанар, стандартад нийцсэн барилга бүхий оношилгоо, эмчилгээний орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан төв байгуулагджээ.

Эх хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эх хүүхдэд тав тухтай орчин бүрдүүлэх, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн Хүрээ амаржих газрын 180 ортой эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 225 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 62.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,024,932,306.8	1,064,827,577.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,134,359.5	97,021,866.5
33	АВЛАГА	182,860,405.7	215,512,632.4
34	УРЬДЧИЛГАА	3,581,596.1	27,939,059.9
35	БАРАА МАТЕРИАЛ	280,732,401.0	228,527,597.5
36	НӨӨЦИЙН БАРАА	5,671,566.9	9,506.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	483,951,977.7	495,816,915.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,617,451,259.7	1,856,362,683.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,617,451,259.7	1,856,362,683.0
39200	Биет хөрөнгө	1,557,492,605.4	1,792,320,533.8
39300	Биет бус хөрөнгө	59,958,654.3	64,042,149.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,642,383,566.5	2,921,190,260.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	160,954,658.0	261,798,284.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	160,954,658.0	261,798,284.1
41300	Өглөг	160,157,593.4	255,599,816.9
41400	Урьдчилж орсон орлого	797,064.5	6,198,467.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,481,428,908.5	2,659,391,976.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,481,428,908.5	2,659,391,976.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	457,818,922.7	457,967,926.8
51200	Хуримтлагдсан үр дүн	1,619,582,435.7	1,802,579,982.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	404,027,550.0	398,844,067.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,642,383,566.5	2,921,190,260.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,917,186,940.4	3,429,869,223.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	416,055,488.9	438,152,868.9
120	Нийтлэг татварын бус орлого	408,081,938.0	431,341,920.4
122	Тусламжийн орлого	7,973,551.0	6,810,948.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,501,131,451.5	2,991,716,354.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,649,166,469.0	3,166,856,536.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,649,166,469.0	3,166,856,536.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,650,432,187.2	2,018,515,957.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,725,198.8	955,089,645.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,802,177.2	122,763,514.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,792,529.2	17,477,127.6
2104	Хангамж, бараа материалын зардал	48,323,150.5	108,973,797.2
2105	Нормативт зардал	437,599,069.0	490,141,022.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,560,585.1	23,665,753.2
2107	Томилолт, зочны зардал	5,521,579.7	7,509,238.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,845,247.4	23,070,456.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,262,650.2	269,825,403.0

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	998,734,281.8	1,148,340,578.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	268,020,471.4	263,012,687.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,432,170.6	80,002.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	201,678,467.2	85,576,966.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	67,774,174.8	177,515,722.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,416,399,890.6	2,416,399,890.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,438,133.8)	(1,438,133.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,414,961,756.8	2,414,961,756.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,422,631.9)	(1,422,631.9)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	115,608.8	115,608.8
9	Тайлант үеийн үр дүн	67,774,174.8	67,774,174.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,481,428,908.5	2,481,428,908.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,481,428,908.5	2,481,428,908.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,842,106.9	5,842,106.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,487,271,015.4	2,487,271,015.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,626,716.3)	(5,626,716.3)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	211,695.1	211,695.1
17	Өмчид гарсан өөрчилөлт	20,260.0	20,260.0
19	Тайлант үеийн үр дүн	177,515,722.6	177,515,722.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,659,391,976.8	2,659,391,976.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,484,920,655.4	3,092,928,259.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,035,892.1	127,906,378.2
120	Нийтлэг татварын бус орлого	93,035,892.1	127,906,378.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,391,884,763.4	2,965,021,881.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,344,988,186.6	2,821,280,023.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,344,988,186.6	2,821,280,023.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,343,586,370.8	1,670,876,849.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,230,202.9	948,189,163.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,542,003.0	120,201,815.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,542,931.3	23,334,609.9
2104	Хангамж, бараа материалын зардал	32,871,271.4	35,170,166.2
2105	Нормативт зардал	326,801,425.9	404,804,858.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,779,531.6	31,468,199.6
2107	Томилот, зочны зардал	5,392,919.9	7,312,726.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,173,750.8	24,121,899.3

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,252,334.0	76,273,410.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,001,401,815.7	1,150,403,173.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	139,932,468.9	271,648,235.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	183,043,580.5	242,750,431.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	183,043,580.5	242,750,431.6
2200	Дотоод эх үүсвэрээр	183,043,580.5	242,750,431.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(183,043,580.5)	(242,750,431.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	572.3	(10,297.0)
14	Бусад эх үүсвэр	31,776.1	25,771.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	31,203.8	36,068.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(43,110,539.4)	28,887,507.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,244,898.9	68,134,359.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,134,359.5	97,021,866.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,354,502,959,200.00	3,059,893,020,998.97	294,609,938,201.03	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,070,864,250,700.00	2,859,723,662,643.81	211,140,588,056.19	93.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,915,718,929,700.00	1,714,417,212,766.98	201,301,716,933.02	89.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,029,537,431,900.00	949,373,226,838.89	80,164,205,061.11	92.2
210101	Үндсэн цалин	504,898,470,700.00	474,203,848,968.84	30,694,621,731.16	93.9
210102	Нэмэгдэл	387,150,687,200.00	336,368,517,694.96	50,782,169,505.04	86.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,808,662,300.00	40,376,781,020.94	3,431,881,279.06	92.2
210104	Урамшуулал	73,413,826,300.00	67,223,449,335.99	6,190,376,964.01	91.6
210105	Гэрээт ажлын хөлс	20,265,785,400.00	31,200,629,818.16	(10,934,844,418.16)	154.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,624,916,300.00	120,337,528,072.26	16,287,388,227.74	88.1
210201	Тэтгэврийн даатгал	96,795,570,600.00	85,593,016,246.12	11,202,554,353.88	88.4
210202	Тэтгэмжийн даатгал	11,295,824,700.00	9,431,765,951.45	1,864,058,748.55	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,289,394,100.00	4,931,249,904.44	358,144,195.56	93.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,537,255,200.00	4,033,628,033.76	503,627,166.24	88.9
210205	Эрүүл мэндийн даатгал	18,706,871,700.00	16,347,867,936.49	2,359,003,763.51	87.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,120,595,600.00	22,869,864,602.66	2,250,730,997.34	91.0
210301	Гэрэл, цахилгаан	8,514,243,000.00	7,639,415,094.02	874,827,905.98	89.7
210302	Түлш, халаалт	9,756,846,300.00	8,483,871,575.43	1,272,974,724.57	87.0
210303	Цэвэр, бохир ус	5,795,663,700.00	5,672,865,112.21	122,798,587.79	97.9
210304	Байрны түрээс	1,053,842,600.00	1,073,712,821.00	(19,870,221.00)	101.9

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	39,093,270,200.00	34,416,282,438.44	4,676,987,761.56	88.0
210401	Бичиг хэрэг	4,036,738,400.00	3,547,927,740.27	488,810,659.73	87.9
210402	Тээвэр, шатахуун	18,606,678,100.00	15,372,355,923.10	3,234,322,176.90	82.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,238,648,300.00	1,992,344,827.19	246,303,472.81	89.0
210404	Ном, хэвлэл	21,913,700.00	8,463,200.00	13,450,500.00	38.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,402,066,000.00	5,152,596,528.40	249,469,471.60	95.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,787,225,700.00	8,342,594,219.48	444,631,480.52	94.9
2105	Нормативт зардал	459,300,696,800.00	400,726,153,902.86	58,574,542,897.14	87.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	418,311,130,700.00	362,106,499,314.83	56,204,631,385.17	86.6
210502	Хоол, хүнс	35,915,517,700.00	34,523,504,502.53	1,392,013,197.47	96.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,074,048,400.00	4,096,150,085.50	977,898,314.50	80.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,388,033,900.00	57,929,392,846.38	19,458,641,053.62	74.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,446,168,100.00	31,918,542,638.16	11,527,625,461.84	73.5
210602	Тавилга	2,145,496,200.00	1,605,223,742.00	540,272,458.00	74.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,072,036,400.00	639,814,165.94	432,222,234.06	59.7
210604	Урсгал засвар	30,724,333,200.00	23,765,812,300.28	6,958,520,899.72	77.4
2107	Томилолт, зочны зардал	8,767,604,500.00	6,228,252,958.00	2,539,351,542.00	71.0
210701	Гадаад албан томилолт	522,313,500.00	264,140,547.00	258,172,953.00	50.6
210702	Дотоод албан томилолт	8,245,291,000.00	5,964,112,411.00	2,281,178,589.00	72.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,400,274,500.00	24,829,100,736.76	4,571,173,763.24	84.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,453,422,500.00	20,860,741,371.52	3,592,681,128.48	85.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	740,566,400.00	605,933,225.00	134,633,175.00	81.8
210803	Даатгалын үйлчилгээ	525,109,400.00	407,112,605.94	117,996,794.06	77.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,880,900.00	97,650,666.26	53,230,233.74	64.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,896,100.00	27,834,132.00	43,061,968.00	39.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,904,301,600.00	1,725,336,628.32	178,964,971.68	90.6
210807	Газрын төлбөр	470,281,500.00	273,045,967.01	197,235,532.99	58.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	72,706,300.00	27,362,103.00	45,344,197.00	37.6

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,012,109,800.00	804,084,037.71	208,025,762.29	79.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,486,106,000.00	97,707,410,370.73	12,778,695,629.27	88.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,993,157,900.00	92,055,141,622.75	11,938,016,277.25	88.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,492,948,100.00	5,652,268,747.98	840,679,352.02	87.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,155,145,321,000.00	1,145,306,449,876.83	9,838,871,123.17	99.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,070,999,066,100.00	1,070,996,347,341.20	2,718,758.80	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,070,917,755,900.00	1,070,917,755,900.00	-	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	81,310,200.00	78,591,441.20	2,718,758.80	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,146,254,900.00	74,310,102,535.63	9,836,152,364.37	88.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	203,908,200.00	203,471,961.00	436,239.00	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,837,500,000.00	1,683,072,505.61	154,427,494.39	91.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,503,269,500.00	37,859,600,036.00	6,643,669,464.00	85.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,202,715,000.00	30,667,199,837.20	2,535,515,162.80	92.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,398,862,200.00	3,896,758,195.82	502,104,004.18	88.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	283,638,708,500.00	200,169,358,355.16	83,469,350,144.84	70.6
220001	Барилга байгууламж	200,252,268,500.00	125,983,358,609.16	74,268,909,890.84	62.9
221001	Их засвар	24,768,630,100.00	23,434,161,438.50	1,334,468,661.50	94.6
222001	Тоног төхөөрөмж	58,617,809,900.00	50,751,838,307.50	7,865,971,592.50	86.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,354,502,959,200.00	3,066,590,390,657.59	287,912,568,542.41	91.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,653,126,271,800.00	1,547,152,206,519.75	105,974,065,280.25	93.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,653,126,271,800.00	1,547,152,206,519.75	105,974,065,280.25	93.6
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,506,156,739,400.00	1,379,638,455,971.99	126,518,283,428.01	91.6
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	-	-
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,506,156,739,400.00	1,379,638,455,971.99	126,518,283,428.01	91.6

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	195,219,948,000.00	139,799,728,165.85	55,420,219,834.15	71.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,487,527,300.00	51,911,605,473.72	575,921,826.28	98.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,614,188,000.00	87,888,122,692.13	12,726,065,307.87	87.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	42,118,232,700.00	-	42,118,232,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	41,162,823,075.96	(41,162,823,075.96)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	47,882,707,402.79	(47,882,707,402.79)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	446	436	10.00	97.8
610001	Төсвийн байгууллага	436	436	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	10	0	10.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33,739	32,273	1,466.00	95.7
620001	Удирдах ажилтан	492	499	(7.00)	101.4
620002	Гүйцэтгэх ажилтан	23,705	22,575	1,130.00	95.2
620003	Үйлчлэх ажилтан	6,727	6,373	354.00	94.7
620004	Гэрээт ажилтан	2,815	2,826	(11.00)	100.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		34,404,956,593.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ		34,317,206,593.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		28,991,004,904.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,256,472,034.00
210101	Үндсэн цалин		2,581,956,865.14
210102	Нэмэгдэл		2,178,792,849.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт		56,076,931.09
210104	Урамшуулал		422,235,994.89
210105	Гэрээт ажлын хөлс		17,409,393.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		637,041,312.56
210201	Тэтгэврийн даатгал		467,286,643.89
210202	Тэтгэмжийн даатгал		57,000,575.97
210203	ҮОМШӨ-ний даатгал		22,940,575.85
210204	Ажилгүйдлийн даатгал		14,977,496.32
210205	Эрүүл мэндийн даатгал		74,836,020.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		244,813,012.88
210301	Гэрэл, цахилгаан		61,170,734.34
210302	Түлш, халаалт		37,711,735.65

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210303	Цэвэр, бохир ус	70,114,090.32
210304	Байрны түрээс	75,816,452.57
2104	Хангамж, бараа материалын зардал	993,269,830.73
210401	Бичиг хэрэг	185,144,636.30
210402	Тээвэр, шатахуун	572,664,777.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,980,327.43
210404	Ном, хэвлэл	3,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,419,690.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,080,400.00
2105	Нормативт зардал	3,135,155,044.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,344,937,001.40
210502	Хоол, хүнс	724,659,443.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,558,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,260,726,981.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,592,973,954.00
210602	Тавилга	209,289,388.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,978,880.00
210604	Урсгал засвар	455,484,759.58
2107	Томилолт, зочны зардал	1,080,640,143.00
210701	Гадаад албан томилолт	0.00
210702	Дотоод албан томилолт	1,080,640,143.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,118,341,893.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,011,286,824.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	31,690,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,639,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	458,108.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	105,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	57,734,630.00
210807	Газрын төлбөр	5,657,331.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,769,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,264,544,651.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,244,472,038.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,020,072,612.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,326,201,689.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,184,983,193.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,184,983,193.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,141,218,496.44
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,394,202.78
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,138,824,293.66
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	87,750,000.00
220001	Барилга байгууламж	15,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	72,750,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,133,121,988.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,133,121,988.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,474,699,880.38

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,253,861,416.49
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,435,913,629.98
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,569,942,681.48
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		5,398,704,380.16
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		(271,834,604.97)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		339,462,295.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		67,627,690.04

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,555.5 сая төгрөгийн 692 алдаа¹ илэрснээс аудитын явцад 133,097.3 сая төгрөгийн 663 алдааг залруулж, 458.2 сая төгрөгийн 29 алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд: Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 34,313.5 сая төгрөгийн 199 алдаа, буруу тусган илэрхийлсэн 98,783.8 сая төгрөгийн 464 алдааг залруулсан.

Аудитаар нийт 113,860.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,377.8 сая төгрөгийн зөрчилд 269 төлбөрийн акт тогтоож, 89,735.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 462 албан шаардлага хүргүүлж, 19,138.7 сая төгрөгийн зөрчилд 650 зөвлөмж, 3,065.6 сая төгрөгийн хариуцлага тооцох 18 албан шаардлага, 542.1 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 2 албан шаардлага өгсөн.

Нийт 113,860.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 450 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 353 байгууллагад дүгнэлт гаргаж, 97 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Бие даан дүгнэлт гаргасан 353 байгууллагаас 289 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй", 59 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", 3 байгууллагын санхүүгийн тайланд "Сөрөг", 2 байгууллагын санхүүгийн тайланд "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 176,853.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 124,186.5 сая төгрөгийн алдааг залруулж, 1,102.2 сая төгрөгийн зөрчилд 268 төлбөрийн акт тогтоож, 29,672.8 сая төгрөгийн зөрчилд 456 албан шаардлага хүргүүлж, 3,065.6 сая төгрөгийн зөрчилд 17 хариуцлага тооцох албан шаардлага, 18,826.2 сая төгрөгийн зөрчилд 649 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 70,104.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 8,910.8 сая төгрөгийн алдааг залруулж, 275.6 сая төгрөгийн зөрчилд 2

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийн акт тогтоож, 60,063.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 312.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлж, 542.1 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүллээ.

Төлбөрийн акт

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд хэрэгжиж дууссан 17 ажлын 129.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.10.5-д “Төсвийн захирагч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад хэрэгжиж дууссан ажлын захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2022 онд хэрэгжиж дууссан 50 ажлын 146.2 сая төгрөгийн барьцааг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд буцааж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч компаниудад олгоогүй барьцаа дансны үлдэгдэл төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Дээд шатны төсвийн захирагчаас үнэ төлбөргүй хуваарилсан 2,041.9 сая төгрөгийн хөрөнгийг харьяа 3 төсвийн байгууллага данс бүртгэлдээ тусгаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсвийн захирагчаас үнэ төлбөргүй хуваарилсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад бэлтгэсэн, улсын комисс хүлээж авсан 25,296.9 сая төгрөгийн барилгад ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулаагүй, 870.6 сая төгрөгийн дууссан их засвар, 2,533.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.5-д “Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ”, 5.4.6-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны

дагуу шийдвэрлэнэ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.5-д Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусах хүртэл захиалагч байгууллага нь "бусад эргэлтийн хөрөнгө" дансанд бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн барилга, их засвар, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд шилжүүлэх талаар арга хэмжээ аваагүй, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлж баригдсан 2019-2022 онд ашиглалтад орсон 28,574.2 сая төгрөгийн 22 барилга, 349.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн яам болон ашиглагч байгууллага данс бүртгэлд давхар бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.5 дахь заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг бүртгэх зөвшөөрлийг ТӨБЗГ-аар гаргуулаагүй, хөрөнгийн давхардуулан бүртгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 4.5 сая төгрөгийн 4 ширхэг дуслын автомат шахуурга, 35.8 сая төгрөгийн 9 ширхэг өвчтөний хяналтын мониторинг, 11.0 сая төгрөгийн 9 ширхэг тарианы автомат шахуурга, нийт 22 ширхэг 51.4 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй, тооллогоор дутагдсан хөрөнгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан хаагчийг тогтоож, хохирлыг төлүүлэхээр хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх.

5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын зардалд Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 26 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж "хөдөөгийн айл өрхүүдэд анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж"-г бэлтгэх 505.5 сая төгрөгийн /6210 ширхэг/ зардлын төсвийг нэмж баталсан байна. Тус ажлын тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгч компаниас 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээний багцыг хүлээн авсан бөгөөд Баянхонгор аймгийн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад тараасан байна. Үүнээс 490.6 сая төгрөгийн 5316 ширхэг хөрөнгийг /26.6 сая төгрөгийн 1109 ширхэг анхны тусламжийн цүнх, 2.6 сая төгрөгийн 3 ширхэг асаргааны багц, 50.3 сая төгрөгийн 1109 ширхэг биеийн халуун хэмжигч, 127 сая төгрөгийн 1127 ширхэг гар массажны аппарат, 168.8 сая төгрөгийн 1109 ширхэг даралтын аппарат, 82.4 сая төгрөгийн 1070 ширхэг сахар хэмжигч аппарат/ Баянхонгор аймгийн 19 эрүүл мэндийн байгууллага хүлээж аваагүй, ЭМС-ын харьяа байгууллагуудад хуваарилах А/452 дугаар

тушаалыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нөхөн гаргасан бөгөөд зориулалт бусаар зарцуулагдсан байх эрсдэлтэй байна.

